

12. Шашин шүтэх эрх

57. Монгол Улс НҮБ-ын гишүүн болсноос хойш хүний эрхийн салбарын үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, түүнээс батлан гаргасан эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн орж, хүний эрхийг баталгаажуулах үйл хэрэгт бусад улс оронтой хамтран ажиллаж ирсэн бөгөөд ардчилсан Монгол Улсад бодит биелэлээ олсон хүний эрхийн нэг нь шашин шүтэх, эс шүтэх явдал юм. Монгол Улсын Үндсэн хуульд шүтэн бишрэх эрх чөлөөг хуульчлан баталгаажуулж, жинхэнэ утгаараа хэрэгжих боломжийг нээж өгснөөр манай орны иргэдийн шүтэн бишрэх эрх чөлөөтэй болсны дээр бусад шашны урсгал орж ирэх, дэлгэрэх нөхцөл бүрдсэн.

58. Шашин шүтэх эрхийн талаар Үндсэн хуульд “Монгол Улсын иргэн шашин шүтэх, эс шүтэх эрхтэй чөлөөтэй” гэж заасан бөгөөд уг эрхийн харилцааг зохицуулахаар УИХ-аас 1993 онд Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, 2003 онд “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”, 1994 онд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс “Шашин-сүм хийдийн талаарх төрийн бодлогын үзэл баримтлалын тухай зөвлөмж”-ийг тус тус батлан гаргасан нь хүний шүтэн бишрэх эрх чөлөөг хангахад бодитой нөлөө үзүүлж, тусгалаа олсон билээ. Өнөөгийн байдлаар Монгол Улсад Будда, Христ, Ислам, Бахай, Бөө мөргөл, Мүүн шашны урсгалын нийт 463 байгууллага улсын бүртгэлд бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаагийн 50 гаруй хувь нь буддын шашны, 40 орчим хувь нь христийн шашны байгууллага юм.